

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАНАА

2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ГЭРЛЭН УРХИ, ДЭЛГЭЦ ТАВИХ
АРГААР ТЭМЦЭХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ГЭРЛЭН УРХИ,
ДЭЛГЭЦ ТАВИХ АРГААР ТЭМЦЭХ

Тендер шалгаруулалтын дугаар:

ОйГ/20240101058

Улаанбаатар хот
2024 он

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙН АГУУЛГА

<u>I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА</u>	8
<u>II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ</u>	Error! Bookmark not defined.
<u>III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА</u>	23
<u>IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ 27 5</u>	
<u>V БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ</u>	34

I БҮЛЭГ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА (ТШЗ)

A. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- | | |
|---|---|
| 1. Тендерийн цар хүрээ | <p>1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу Өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон ажил, түүний дагалдах үйлчилгээ (цаашид “ажил” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>1.2. Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> <p>1.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай Өгөгдлийн хүснэгтэд заана.</p> |
| 2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг | <p>2.1. Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг Өгөгдлийн хүснэгтэд тусгана.</p> |
| 3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж | <p>3.1. Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.</p> |
| 4. Худалдан авах ажиллагааны цахим систем | <p>4.1. Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.</p> |
| 5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх | <p>5.1. Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.</p> <p>5.2. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.</p> |
| 6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага | <p>6.1. Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.</p> <p>6.2. Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.</p> <p>6.3. Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан байна.</p> |

- 6.4. Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.
- 6.5. Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.
- 6.6. Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.
- 6.7. Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.
 - 7.1. Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.
 - 7.2. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
 - 7.4. ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
 - 7.5. Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг
 - 8.1. Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:
I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;
II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;
III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;
IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;
V Бүлэг. Тендерийн жишиг маягт;
VI Бүлэг. Гэрээний нөхцөл;
 - 8.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
 - 8.3. Сонирхогч этгээд ТШЗ, Өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

- 9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах**
- 9.1. Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.
- 9.2. Тодруулга авах хүсэлтийг Өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.
- 9.3. Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.
- 9.4. Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.
- 9.5. Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.
- 10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт**
- 10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцно.
- 10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.
- 11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах**
- 11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.
- 11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.
- 11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.
- В. ТЕНДЕР БЭЛТГЭХ**
- 12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл**
- 12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.
- 12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжүүлэх ажил гүйцэтгүүлэх тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

- 13. Тендерийн иж бүрдэл**
- 12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.
 - 12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.
- 14. Тендерийн жишиг маягтууд**
- 13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн ажил гүйцэтгэх техникийн болон үнийн санал байна.
 - 13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:
 - 13.2.1. ТШЗ-ны **14Error! Reference source not found.**-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;
 - 13.2.2. Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;
 - 13.2.3. ТШЗ-ны **15Error! Reference source not found.**-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;
 - 13.2.4. оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;
 - 13.2.5. тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;
 - 13.2.6. санал болгож буй ажил ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;
 - 13.2.7. ТШЗ-ны 21-д заасан ажлын төсөв;
 - 13.2.8. ТШЗ-ны 21.7-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;
 - 13.2.9. Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.
 - 13.3. Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.
 - 13.4. Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.
- 15. Хувилбарт санал**
- 14.1. Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.
 - 15.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

- 16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг**
- 16.1. Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:
- 16.1.1. ТШЗ-ны 14.1**Error! Reference source not found.**-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.
- 16.1.2. Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 16.2. Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:
- 16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;
- 16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг.
- 16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.
- 16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.
- 16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
- 17. Чадавхын болон туршлагын шаардлага**
- 17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.
- 17.2. Тендерт оролцогч нь хуулийн 15 дугаар зүйлд зааснаар гэрээний үүргийн биелэлтийг хангах санхүүгийн чадавхын талаар захиалагчаас ТӨХ-д заасан шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангасан байна. Энэхүү шалгуур үзүүлэлт, шаардлагыг нотлох дараах баримт бичгээс ТӨХ-д заасныг ирүүлнэ:
- 17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.
- 17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.
- 17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

- 18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт**
- 18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.
- 18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалzan үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.
- 18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.
- 19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт**
- 19.1. Хуулийн 17.4-т зааснаар оролцогч Өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.
- 19.2. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.3. Ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 19.4. ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.
- 20. Санал болгож буй ажил тендер шалгаруулалтын баримт бичгийн шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг**
- 20.1. Санал болгож буй ажил нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.
- 20.2. III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.
- 20.3. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- 21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт**
- 21.1. Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.
- 21.2. Тендерт ирүүлэх өртгийн төсвийг холбогдох эрх

- бүхий байгууллагаас баталсан норм, нормативыг үндэслэн нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг эрх бүхий этгээдээр баталгаажуулж ирүүлнэ.
- 21.3. Тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.
- 21.4. ТШЗ-ны 21.2**Error! Reference source not found.**-т заасан төсвийн нийт нийлбэр нь арифметик алдаагүй боловч V бүлгийн маягт 1-д заасан үнээс зөрүүтэй бол төсвийн нийт нийлбэрийг санал болгосон үнэ гэж үзнэ.
- 21.5. ТШЗ 21.1-т заасны дагуу үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.
- 21.6. Хууль болон Өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.
- 21.7. Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь ажлын хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт ирүүлнэ.
- 22. Тендерийн валют**
- 22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.
- 23. Тендер хүчинтэй байх хугацаа**
- 23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.
- 23.2. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1**Error! Reference source not found.**-т заасан хугацааг сунгаж болно.
- 23.3. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24**Error! Reference source not found.**-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.
- 23.4. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд

- оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.
- 24. Тендерийн баталгаа**
- 24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 24.2. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.
- 24.3. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.
- Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ**
- 25. Тендер баталгаажуулах, илгээх**
- 25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24**Error! Reference source not found.**-т зааснаар илгээнэ.
- 25.2. ТШЗ-ны 25.1**Error! Reference source not found.**-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.
- 25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1 зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.
- 25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн маягт **Error! Reference source not found.**7-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.
- 25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болго баримт бичгийг Өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.
- 26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа**
- 26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг Өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.
- 26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр Өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

- 27. Тендерийн талаар тодруулга авах**
- 28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх**
- 29. Тендерийг үнэлэх**
- 30. Арифметик алдааг залруулах**
- 31. Давуу эрх олгох**
- 32. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт**
- 33. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох**
- 27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
- 28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны **Error! Reference source not found.**-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.
- 29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.
- 30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.
- 30.2. ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.
- 31.1. Захиалагч нь хуулийн 8.4, 8.7-д зааснаар давуу эрх олгоход оролцогчийн ирүүлсэн нотлох баримтыг үндэслэн хууль болон холбогдох аргачлал, зааврын дагуу үнийг хийсвэрээр бууруулж тооцно.
- 31.2. ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д заасан нотлох баримт ирүүлээгүй тохиолдолд давуу эрх олгохгүй ба энэ нь тухайн оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болохгүй.
- 32.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.
- 33.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална.
- 33.1.1 ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;
- 33.1.2 ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д заасны дагуу санал болгосон үнийн хөнгөлөлт тооцох;
- 33.1.3 ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;
- 33.1.4 ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;
- 33.1.5 ТШЗ-ны 31.1-д зааснаар давуу эрх олгох;
- 33.1.6 ТШЗ-ны **Error! Reference source not found.**-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.
- 33.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал

**34 Тендерийг
эрэмбэлэх**
**34 Оролцогчийн
чадавхыг дахин
магадлах**

- болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцоходоо дараах аргачлалыг баримтална:
- 33.2.1 багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох
- 33.2.2 хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлоходоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 35-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;
- 33.2.3 дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.
- 33.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.
- 33.4. ТШЗ-ны 33.3**Error! Reference source not found.**-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.
- 34.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5-д заасныг баримтална.
- 35.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.
- 35.2. ТШЗ-ны 35.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1**Error! Reference source not found.**-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.
- 35.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 36 Мэдэгдэл хүргүүлэх**
- 37 Гүйцэтгэлийн баталгаа**
- 38 Урьдчилгаа төлбөр**
- 39 Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах**
- 36.1 Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.
- 37.1 Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 37.2 Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.
- 38.1 Гэрээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа материал худалдаж авах болон ажил эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгох шаардлагатай бол захиалагч урьдчилгаа төлбөр олгох хувийг Өгөгдлийн хүснэгтэд заана.
- 38.2 Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөр авах хүсэлтийг уг төлбөрийн дагуу санхүүжүүлэх ажлын нэр төрөл, тоо хэмжээ, төсөв, ажил гүйцэтгэх хуваарийн хамт ТШЗ-ны 38.1-д заасан үнийн дүнгээс багагүй хэмжээний мөнгөн дүнтэй урьдчилгаа төлбөрийн баталгааг холбогдох этгээдээр гаргуулан захиалагчид ирүүлнэ.
- 38.3 Захиалагчийн хүлээн авсан, шаардлага хангасан урьдчилгаа төлбөрийн баталгаа нь гэрээний салшгүй хэсэг байна.
- 39.1 Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягтыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.
- 39.2 Захиалагч тендер шалгаруулалтын үр дунд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.
- 39.3 Шалгарсан оролцогч ТШЗ-ны 39.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.
- 39.4 Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТШЗ-ны
холбогдох
заалт

А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- ТШЗ 1.1** Захиалагч: **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ОЙН ГАЗАР**
- ТШЗ 1.1** Тендер шалгаруулалтын нэр: **ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ГЭРЛЭН УРХИ, ДЭЛГЭЦ ТАВИХ АРГААР ТЭМЦЭХ**
- ТШЗ 1.1** Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: **ОйГ/20240101058**
- ТШЗ 1.2** Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:
Багц № 3: Хэнтий аймгийн Баян-Адрага, Дадал сумдын ойн санд;
- ТШЗ 1.3** Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“ҮГҮЙ”**
- ТШЗ 2.1** Санхүүжилтийн эх үүсвэр нь: **УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ**
- ТШЗ 2.1** Нийт төсөвт өртөг: **96,000,000.00 (ерэн зургаан сая) төгрөг.**
Багц № 3: 96,000,000.00 (ерэн зургаан сая) төгрөг.

Б. АГУУЛГА

- ТШЗ 9.1Error! Reference source not found.** Тендер шалгаруулалтын баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 301 тоот**
Хүлээн авагчийн нэр: **ОЙН НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Г.БАТ**
Хаяг: **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН II БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 301 ТООТ,**
Утасны дугаар: **7711-1180**
Цахим шуудангийн хаяг: info@forest.gov.mn
- ТШЗ Error! Reference source not found.** Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: **“ҮГҮЙ”**

В. ТЕНДЕР БЭЛТГЭХ

- ТШЗ 12.1** Тендер шалгаруулалтын хэл: **“МОНГОЛ ХЭЛ”**
- ТШЗ 15.1** Хувилбарт санал ирүүлэхийг: **“ЗӨВШӨӨРӨХГҮЙ”**
- ТШЗ 16.1.2** Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: **“ШААРДАНА”**
1. **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГҮҮЛСЭН ГАЗАР, БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, ХАЯГИЙГ**

ТОДОРХОЙЛСОН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЭХЭЭС ХИЙСЭН ХУУЛБАР, ЭСВЭЛ ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН УЛСЫН ТҮҮНТЭЙ АДИЛГАХ БУСАД БАРИМТ БИЧИГ;

2. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ ЭТГЭЭДИЙН ИТГЭМЖЛЭЛ;**
3. **ШҮҮХИЙН ТУСГАЙ АРХИВЫН ЛАВЛАГАА, ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗРЫН ТОДОРХОЙЛОЛТ, ТАТВАРЫН ӨРГҮЙ ТОДОРХОЙЛОЛТ, ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАТВАРЫН ӨРГҮЙ ТОДОРХОЙЛОЛТЫГ ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР ИРҮҮЛНЭ.**
 - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг цахим хэлбэрээр ирүүлнэ.
 - Жич: Дээр 2 лавлагaa авах зааварчилгаатай www.tender.gov.mn цахим системийн хэрэглэгчийн хөтөч цэсээс танилцана уу,
4. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ТАТВАР, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТӨЛӨЛТИЙГ** Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (*E-Mongolia*) системээс шалгана.
5. **ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 4.1.5 -Д ЗААСАН ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЭТГЭЭДЭЭС ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАСАН ӨДРӨӨС ХОЙШ АВСАН, ШАЛГАХ БОЛОМЖТОЙ QR КОД БУХИЙ “ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛНЭ. УГ ТОДОРХОЙЛОЛТОД ТӨЛӨГДӨЖ ДУУСААГҮЙ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ “ХЭВИЙН БУС” БАЙГАА ТОХИОЛДОЛД ТЕНДЕРЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.** (Зээлийн мэдээллийн сангийн тодорхойлолтыг www.sainscore.mn, www.burenscore.mn) хаягаар хандан авна.
6. **ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ: ТҮРГЭН ХӨРВӨХ ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭ НЬ БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН 50 ХУВИАС БАГАГҮЙ БАЙНА.**
7. **ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙГ ХАНГАХ МӨНГӨН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ДАРААХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН АЛЬ НЭГЭЭР ЭСВЭЛ НИЙЛБЭРЭЭР ТУС ТУС ТОДОРХОЙЛНО. ҮҮНД:**
 - Байгууллагын дансны үлдэгдэл* /Харилцагч банкны тодорхойлолт, тендер нээхээс 7 хоногийн өмнө харилцагч банкнаас авсан байх/
 - Арилжааны банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. Тухайн зээл нь судлагдсан байх шаардлагатай. Тухайн тендерийн ажилтай холбоотой ямар нэгэн нөхцөл шаардлага тавихгүйгээр олгох зээлийг үнэлгээнд авч үзэх бөгөөд бусад тохиолдолд тус шаардлагыг хангаагүй гэж үзнэ. Үнэт цаас, Засгийн газрын бонд болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цааснууд. /Хувь хүн эзэмшиж буй үнэт цаас, хадгаламж хамаарахгүй/

8. ТУСЛАН ГҮЙЦЭТГЭГЧ, ТҮНШЛЭЛИЙН ГИШҮҮДИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА, ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭРХ АВСАН ГЭРЭЭНИЙ ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ: “ШААРДАНА”

- Түншлэлийн гишүүн тус бүр ерөнхий шаардлага хангасан байх бөгөөд холбогдох мэдэгдэл, баримт бичгийг энэ хуулийн 7.2, 7.3-т зааснаар ирүүлнэ.
- Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна. Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын 2.3.1-д зааснаар түншлэлийн гэрээг цахим системээр баталгаажуулсан байна. Мөн түншлэлийн гэрээний хувийг тендерийн хамт ирүүлэх.
- Түншлэлийн гэрээнд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн болон түншлэлийн гишүүдийг тодорхойлж, түншлэлийн гишүүд тус бүрийн гүйцэтгэх ажил, үнийн дүн, хувийг тодорхой тусгасан байна.
- Түншлэлийн аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүн томилох.
- Нийт гэрээний гүйцэтгэл, түүний дотор төлбөрийг зөвхөн төлөөлөх эрх бүхий гишүүнтэй тооцохыг хамтран ажиллах гэрээгээр зохицуулсан байх.
- Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна. Түншлэлийн гишүүн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.
- Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй оролцох бол гүйцэтгүүлж болох хувь хэмжээ нь гэрээний үнийн дунгийн 20 хүртэл хувь байна. Туслан гүйцэтгэгчтэй холбоотойгоор дараах материалыг ирүүлэх шаардлагатай.
- Тендерт оролцогч нь туслан гүйцэтгэгчтэй цахим системээр дамжуулан гэрээ байгуулсан байна. Гэрээнд туслан гүйцэтгэгчийн гүйцэтгэх ажил үүрэг, гэрээний үнийн дүн, хугацааг тодорхой тусгасан байна. Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.
- Туслан гүйцэтгэгч нь гүйцэтгэх үүргийнхээ дагуу хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.
- Туслан гүйцэтгэгч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд уг мэдээллийг “Төрийн мэдээлэл солилцооны ХҮР систем”-ээр дамжуулан шалгана.
- Туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

ТШЗ 18.1

Санхүүгийн чадавхын шаардлага: “ШААРДАНА”

СҮҮЛИЙН 2 ЖИЛ БҮЮУ 2022, 2023 ОНУУДЫН АЛЬ НЭГ

**ЖИЛИЙН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ДУНДАЖ ХЭМЖЭЭ НЬ
БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН 50 ХУВИАС БАГАГҮЙ БАЙНА.
Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:**

ТШЗ 18.2

- СҮҮЛИЙН 2 ЖИЛ БУЮУ 2022, 2023 ОНУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХОЛБОГДОХ АУДИТИН ДУГНЭЛТ ИРҮҮЛНЭ.**
- СҮҮЛИЙН 2 ЖИЛ БУЮУ 2022, 2023 ОНУУДЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУГАЦААНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛНЭ.**

ТШЗ 19.1

Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “ШААРДАНА”

- СҮҮЛИЙН 2 ЖИЛ БУЮУ 2022, 2023 ОНУУДЫН АЛЬ НЭГ ЖИЛД ТӨСӨВТ ӨРТГИЙН 50 ХУВИАС БАГАГҮЙ УНИЙН ДҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН БАЙНА. УГ АЖЛЫН ГЭРЭЭ, АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ЗАХИАЛАГЧИЙН ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТЫГ ХАВСАРГАНА.**
- ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН САНАЛ БОЛГОСОН НИЙТ ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛТАН, АЖИЛЧДЫН 30 ХУВИАС ДООШГҮЙ ӨӨРИЙН ҮНДСЭН АЖИЛТАН, АЖИЛЧИД БАЙНА. САНАЛ БОЛГОЖ БУЙ ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТӨЛСӨН БОЛОХЫГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТӨЛӨЛТИЙН ТАЙЛАНГААС ШАЛГАЖ ҮЗНЭ. ХЭРЭВ ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БОЛ ШААРДЛАГАД НИЙЦЭЭГҮЙ ТЕНДЕР ГЭЖ ҮЗНЭ.**
- ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙГ УДИРДАХ БОЛОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНҮҮДЫН ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙГ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛСАН ТАНИЛЦУУЛГА ИРҮҮЛЭХ,**
- ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БАГИЙГ УДИРДАХ БОЛОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНҮҮДЫН ЧАДВАРЫН МЭДЭЭЛЛИЙГ ДЭЛГЭРЭНГҮЙ АГУУЛСАН ТАНИЛЦУУЛГА ИРҮҮЛЭХ,**

Гүйцэтгэх үүрэг	Мэргэжил	Тоо	Мэргэжлээрээ ажилласан жил	Үндсэн /Гэрээт эсэх/
Ерөнхий инженер	Ойн инженер	1	10	Үндсэн
Ойн инженер	Ойн инженер	1	3	Үндсэн
Биологич	Биологич	1	3	Гэрээт
Жолооч	Жолооч	1	9	Гэрээт

Улирлын ажилтан		10	1	Гэрээт
--------------------	--	----	---	--------

5. **ҮНДСЭН АЖИЛТНЫ МЭДЭЭЛЛИЙГ ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ"-ЭЭР ДАМЖУУЛАН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГААС ШАЛГАНА.** “Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д инженер, техникийн ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг лавлах шаардлагатай. Дээрх мэдээлэл зөрүүтэй бүртгэгдсэн бол тендерийн нээлтээс өмнө БШУЯ-ны Мэдээллийн технологи статистикийн хэлтэст хандаж дээд боловсролын удирдлагын мэдээллийн системд бүртгүүлнэ уу. Дээрх бүртгэл хийгдээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болохыг анхаарна уу. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) системээс мэдээлэл шалгах заавартай дараах холбоосоор танилцана уу. <https://bit.ly/3J1QmHZ>
6. **ГАДААДЫН ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ ТӨГССӨН БОЛ ДИПЛОМОЫН ХУУЛБАРЫГ ОРЧУУЛАН ИРҮҮЛНЭ.**
7. **ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААС МЭРГЭЖИЛТЭЙ АЖИЛЧДАД ОЛГОСОН МЭРГЭЖЛИЙН ҮНЭМЛЭХ, ЗӨВЛӨХ ИНЖЕНЕРИЙН ГЭРЧИЛГЭЭГ ТУС ТУС НОТАРИАТААР ГЭРЧЛҮҮЛЭН ТЕНДЕРИЙН МАТЕРИАЛД ХАВСАРГАН ИРҮҮЛНЭ.**
8. **ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТНЫ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БОЛОХЫГ “ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦООНЫ ХУР СИСТЕМ”. ЭЭР ДАМЖУУЛАН ШАЛГАНА. СҮҮЛИЙН 6 САР ТАСРАЛТГҮЙ ТӨЛСӨН БАЙХ ШААРДЛАГАТАЙ. ҮНДСЭН БОЛОН ТУСЛАХ АЖИЛТNUУДЫН БИЧИГ БАРИМТЫГ ДУТУУ ИРҮҮЛЭХ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ДЭЭР ДУРДСАН ХУГАЦААНД ТӨЛӨГДӨӨГҮЙ ТОХИОЛДОЛД УГ ТЕНДЕРЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.**
9. **ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧИНТЭЙ ТЭМЦЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙСАН ТУРШЛАГАТАЙ ОЙН АЖ АХУЙН ИНЖЕНЕР, ОЙ ЗҮЙЧ, БИОЛОГИЧ, ШАВЖ СУДЛААЧ БАЙХ.**

Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“ШААРДАНА”**

- 2.1 **ӨРӨӨСГӨЛ ХУР ЭРВЭЭХЭЙ ГЭРЛИЙН ДОЛГИОНООР МЭДЭРЧ ТАТАГДАН ИРЭХ /тусгай/ ЗОРИУЛАЛТ БҮХИЙ ГЭРЛЭН УРХИТАЙ БАЙХ;**
- 2.2 **НИЙТ ТАЛБАЙД 4-5 УДАА ЗӨӨЖ БАЙРЛУУЛАН ТЭМЦЛИЙН АЖИЛ ЯВУУЛАХ 50-80 ШИРХЭГ ГЭРЛЭН УРХИ ТЭМЦЛИЙН АЖИЛД АШИГЛАХ;**
- 2.3 **ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ ГЭРЛЭН УРХИЙГ ЗӨӨВӨРЛӨХ БАГА БОЛОН ДУНД ОВРЫН АВТОМАШИНТАЙ БАЙХ;**

- 2.4 ХЭЭРИЙН АЖИЛД АЖИЛЧДЫН БАЙРЛАХ ГЭР,**
МАЙХАНТАЙ БАЙХ,
- 2.5 ТЭМЦЛИЙН АЖЛЫН ӨМНӨХ БОЛОН ДАРААХ СУДАЛГААНЫ АЖИЛД ХЭРЭГЛЭГДЭХ ШАВЖ ЦУГЛУУЛАХ ДЭЛГЭЦҮҮДТЭЙ БАЙХ,**
- БАЙРШИЛ ТОГТООГЧ GPS,
 - БИЧИЛ ЦАГ УУР ХЭМЖИГЧ,
 - ОЙН БҮРТГЭЛ ТООЛЛОГЫН ХЭМЖИЛТИЙН БАГАЖУУД
 - ШАВЖ ҮХҮҮЛЭХ, ХАДГАЛАХ САВ,
 - ШАВЖ БАРИХ ХОВОЙ, (САЧОК)
 - СОРОГЧ БАГАЖ,
 - ШТАНГЕНЦИРКУЛЬ,
 - ШАВЖ БАРИХ УРХИ (ЛОНХОН, ТАВГАН, ГЭРЛЭН),
 - ЭРВЭЭХЭЙ ХУСАЖ ЦУГЛУУЛАХ ТӨРӨЛ БУРИЙН МАЛТУУРУУД;
 - ЭРВЭЭХЭЙ ЦУГЛУУЛАХ ТӨРӨЛ БУРИЙН ХЭМЖЭЭТЭЙ ШУУДАЙ;
- 2.6 4Х2 МЕТРИЙН ХАРЬЦААТАЙ ДЭЛГЭЦ /ДАВУУ МАТЕРИАЛ/ 10-ААС ДООШГҮЙГ ТЭМЦЛИЙН АЖИЛД АШИГЛАХ,**
- 2.7 220 ВТ-ЫН ХҮЧДЭЛ ГАРГАХ ХҮЧИН ЧАДАЛТАЙ ЗӨӨВРИЙН ЦАХИЛГААН ҮҮСГҮҮР 10-ААС ДООШГҮЙГ ТЭМЦЛИЙН АЖИЛД АШИГЛАХ,**
- 2.8 ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ ГЭРЭЭГ ГҮЙЦЭТГЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, МАШИН МЕХАНИЗМУУДЫН ЖАГСААЛТЫГ В БУЛГИЙН МЯЯГТ-3-Н ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ. ТҮРЭЭСЭЭР ХЭРЭГЛЭХ БОЛ ГЭРЧИЛГЭЭНИЙ ХУУЛБАРЫГ НОТАРИАТААР БАТЛУУЛЖ, ТҮРЭЭСИЙН ГЭРЭЭГ ХАВСАРГАНА. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, БАГАЖИЙН ХУВЬД ГЭРЭЛ ЗУРАГ ИРҮҮЛНЭ.**

Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлага:“ШААРДАНА”

- 3.1 СҮҮЛИЙН 2 ЖИЛ БУЮУ 2022, 2023 ОНУУДАД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ЖАГСААЛТЫГ ИРҮҮЛНЭ. ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ТУРШЛАГУУДЫГ ӨМНӨХ ЗАХИАЛАГЧТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХУУЛБАР, ГЭРЭЭ ДУГНЭСЭН АКТ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР ӨМНӨХ ЗАХИАЛАГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ /ЭХ ХУВЬ ЭСВЭЛ НОТАРИАТААР ГЭРЧЛҮҮЛЭХ-/ИЙГ ҮНДЭСЛЭН ГЭРЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАН ҮЗНЭ. /ижил төстэй ажил гэдэгт ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил гүйцэтгэж байсан туршлагыг голлон авч үзнэ./ СҮҮЛИЙН 2 ЖИЛД НИЙЛҮҮЛСЭН БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХАНГАЛТГҮЙ БАЙСАН НЬ ӨМНӨХ ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОДОРХОЙЛОЛТООР БОЛОН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ХЯНАЛТААР НОТЛОГДСОН ТОХИОЛДОЛД ТЕНДЕРЭЭС ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.**

- 3.2 БАТЛАГДСАН ТӨСӨВТ ӨРТГИЙН ҮНИЙН ДҮНГИЙН 50**

**ХУВИАС БАГАГҮЙ ҮНИЙН ДҮНТЭЙ ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫГ
ТШЗ 19.1-Т ЗААСАН ХУГАЦААНД ДООД ТАЛ НЬ НЭГ УДАА
ГҮЙЦЭТГЭСЭН БАЙХ.**

Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага:
“ШААРДАНА”

№	Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Дууссан эсвэл дуусах хугацаа

Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: **“ШААРДАНА”**

- 4.1 ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ БОЛОН ТУСГАЙ НӨХЦӨЛИЙГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,**
- 4.2 ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧИНТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭХ БУХИЙ Л ХУГАЦААНД БҮРЭН ХАРИУЦАН, ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭН АЖИЛЛАХ ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,**
- 4.3 ЗАХИАЛАГЧ НИЙГМИЙН ДААТГАЛ, ТАТВАРЫН БАЙГУУЛЛАГУУДААС ТОДОРХОЙЛОЛТ ХҮСЭХЭД ТАТГАЛЗАХ ЗҮЙЛГҮЙ ТУХАЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН АЛБАН МЭДЭГДЭЛ,**
- 4.4 АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ЧАНАРЫН ЗӨРЧИЛ, ГОЛОГДОЛ ГАРСАН ТОХИОЛДОЛД ТҮҮНИЙГ ЗАСАХ, ЗАЛРУУЛАХ ТУХАЙ ШААРДЛАГА ӨГӨХӨД ҮЛ МАРГАЛДАХ ЖУРМААР БИЕЛҮҮЛЭХИЙГ ЗӨВШӨӨРЧ БАЙГАА ТАЛААРХ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН БИЧИГ, ТОДОРХОЙЛОЛТ,**
- 4.5 ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ДАГУУ ТООЦСОН ТӨСӨВ ИРҮҮЛНЭ. УГ ТӨСӨВТ ХОЛБОГДОХ ТАТВАР ХУРААМЖ, ДААТГАЛЫГ БҮРЭН ХАМРУУЛСАН БАЙНА.**
- 4.6 ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ, ҮНЭЛЭГДСЭН ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ БАТАЛГААЖУУЛЖ ИРҮҮЛЭХ,**
- 4.7 САНАЛ БОЛГОЖ БҮЙ ГОЛЛОХ МЭРГЭЖИЛТНҮҮДТЭЙ БАЙГУУЛСАН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭНИЙ ХУУЛБАР, НОТАРИАТААР БАТАЛГААЖУУЛАН ИРҮҮЛЭХ,**
- 4.8 ТЕНДЕРТ ШАЛГАРСАН ТОХИОЛДОЛД ГЭРЭЭНИЙ ҮНЭ БОЛОН ЗАХИАЛАГЧААС ТОГТООСОН ҮЕ ШАТНЫ ХУВААРТЬ ЗААСАН ХУГАЦААНД БАГТААН ЗУРАГ ТӨСВИЙН ДАГУУ ЧАНАРЫН ӨНДӨР ТҮВШИНД ТУХАЙН АЖЛЫГ ГҮЙЦЭТГЭН ДУУСГАЖ ХҮЛЭЭЛГЭН ӨГӨХ БАТАЛГААГ БИЧГЭЭР ГАРГАЖ ИРҮҮЛНЭ.**
- 4.9 СҮҮЛИЙН 2 ЖИЛИЙН АЛЬ НЭГ ЖИЛД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ХИЙСЭН ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС ӨГСӨН ТОДОРХОЙЛОЛТ ИРҮҮЛЭХ. ГЭРЭЭ БОЛОН АЖИЛ ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН КОМИССЫН АКТЫН ХУУЛБАРЫГ ХАВСАРГАНА.**

**ДУУСААГУЙ ГЭРЭЭНИЙ ХУВЬД ТАЙЛБАР ХИЙСЭН БАЙНА.
МЭДЭЭЛЛИЙГ V БҮЛГИЙН МАЯГТ-5 ДАГУУ ИРҮҮЛЭХ.**

4.10 ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ОЛОН БАГЦАД ТЕНДЕР ИРҮҮЛЭХ БОЛОН ӨӨР ИЖИЛ ТӨРЛИЙН АЖИЛ ГҮЙЦЭТГЭЖ БАЙГАА БОЛ ЗӨВХӨН ТУХАЙН БАГЦАД АЖИЛЛУУЛАХ ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТНЫГ САНАЛ БОЛГОСОН ТЕНДЕР ИРҮҮЛНЭ. (ХЭРЭВ ЗАХИАЛАГЧИЙН ЗАРЛАСАН БУСАД ТЕНДЕРҮҮДЭД САНАЛ БОЛГОСОН ИНЖЕНЕР, ТЕХНИКИЙН АЖИЛТАН ДАВХАЦСАН ТОХИОЛДОЛД ТАТГАЛЗАХ ҮНДЭСЛЭЛ БОЛНО.)

ТШЗ 19.2

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:
“ШААРДАНА”

- 1. ШААРДСАН ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЛИЙГ V БҮЛГИЙН МАЯГТ-2 ДАГУУ ИРҮҮЛЭХ;**
- 2. ОРОЛЦОГЧИЙН ТУРШЛАГЫГ ХАРУУЛАХ ЗААСАН ХУГАЦААНД ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖИЛ ГҮЙЦЭТГЭСЭН ГЭРЭЭНИЙ ТАЛААР V БҮЛГИЙН МАЯГТ-4 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ;**
- 3. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД АШИГЛАХААР ЗААСАН ҮНДСЭН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН МЭДЭЭЛЭЛ, (ӨӨРИЙН ӨМЧЛӨЛ, ЭЗЭМШЛИЙН, ТҮРЭЭСЛЭХ ГЭХ МЭТ) ТАЛААР V БҮЛГИЙН МАЯГТ-3 ДАГУУ БЭЛТГЭН ИРҮҮЛЭХ;**
- 4. ТЕХНИКИЙН ЧАДАВХ БОЛОН ТУРШЛАГЫН ТАЛААР ЗААСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ШААРДЛАГЫГ ХАНГАЖ БУЙГ НОТЛОХОД ШААРДЛАГАТАЙ БУСАД БАРИМТЫГ ХАВСАРГАН ИРҮҮЛЭХ**

ТШЗ 19.3

Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: **“ШААРДАНА”**

“ОЙН МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛЛАХ ЖУРАМ”-ЫН 4.1.2 ДАХЬ ЗААЛТАД ЗААСАН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙНА. ҮҮНД:

- ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖ, ӨВЧНИЙ СУДАЛГАА ХИЙХ, ТЭДГЭЭРТЭЙ ТЭМЦЭХ ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭРХТЭЙ БАЙХ**

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА НЬ ДООР ДУРДСАН ШАЛГУУРЫГ ХАНГАСАН БАЙНА. ҮҮНД:

(ажил гүйцэтгэхээр заасан хугацаанаас хойш 3 сараас доошигүй хугацаанд хүчинтэй байна)

ТШЗ 21.6

Оролцогчийн санал болгосон унийг гэрээний хэрэгжилтийн явцад:
“ТОХИРУУЛАХГҮЙ ТОГТМОЛ БАЙНА”

ТШЗ 24.1

Тендерийн баталгаа: **ШААРДАХГҮЙ.**

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

ТШЗ 25.5 Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:
ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧ НЬ ХУВЬ ХУНИЙ НУУЦЫН ТУХАЙ БОЛОН БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИУДААР ИЛ БОЛГОХЫГ ХОРИГЛОСОН МЭДЭЭЛЛИЙГ ТУСАД НЬ ФАЙЛ ҮҮСГЭН ИРҮҮЛНЭ. ТУС ФАЙЛЫН ЭХЭНД ТЭДГЭЭР МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ ҮНДЭСЛЭЛИЙГ БИЧГЭЭР ТАЙЛБАРЛАЖ, ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧИЙН ЭРХ БУХИЙ ЭТГЭЭД БАТАЛГААЖУУЛАН V БҮЛГИЙН МАЯГТ 7-ЫН ДАГУУ ИРҮҮЛНЭ.

ТШЗ 26.1 Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:
Огноо: **2024 оны 07 дугаар сарын 12-ны өдөр**
Цаг: **10 цаг 00 минут**

ТШЗ 26.2 Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.
Огноо: **2024 оны 07 дугаар сарын 12-ны өдөр**
Цаг: **10 цаг 30 минут**
Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: **МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ТӨРИЙН ӨМЧИЙН П БАЙР, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОЙН ГАЗАР, 3 ДАВХАР, 301 ТООТ**

Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ

ТШЗ 31.1 Давуу эрх тооцуулахад шаардлагатай мэдээлэл, баримт бичиг: **“ҮГҮЙ”**
ТШЗ 32.1 Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: **“ҮГҮЙ”**

Е. ШИЙДВЭР ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

ТШЗ 37.1 Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: **“ТИЙМ” ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 3 ХУВИАР ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА ИРҮҮЛНЭ.**

Ё. БУСАД

ТШЗ 38.1 Урьдчилгаа төлбөр олгох эсэх: **“ҮГҮЙ”**

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА
Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ГЭРЛЭН УРХИ, ДЭЛГЭЦ ТАВИХ АРГААР ТЭМЦЭХ АЖИЛ

ТЭМЦЛИЙН АЖИЛ
ХИЙХ ГАЗРУУД,
ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН
АГУУЛГА ҮЕ ШАТУУД
БЭЛТГЭЛ

Гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажил 3000 га талбайд:
Багц № 3: Хэнтиййн аймгийн Баян-Адрага, Дадал сумдын ойн санд 3000 га талбайд ажлыг зохион байгуулна.

- Багаж тоног төхөөрөмжүүдийн техникийн паспорт, техникийн үзүүлэлтүүдийг нотлох баримт бичгийг хавсарган ирүүлэх;
 - Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ орон нутаг болон ЦУОШГ-аас тухайн бүс нутгийн цаг уурын мэдээг урьдчилан авсан байх;
 - Тэмцлийн ажилд хэрэглэгдэх техник, тоног төхөөрөмжүүдийн техник үйлчилгээг бүрэн хийн, тэмцлийн ажилд гаргахад бэлэн болгосон байх;
 - Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлыг явуулах технологийн карт боловсруулсан байна.
 - Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд ашиглах 1:100000-ын байр зүйн болон 1:50000-ны масштабтай ойн тархалтын зураг дээр тэмцлийн ажил явуулах талбайг тэмдэглэх;
 - Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг бүртгэх загвар бэлтгэсэн байх;
 - Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил гүйцэтгэх технологи болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа бэлтгэх;
 - Улирлын болон түр ажилчдыг дадлагажуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар анхааруулга өгөх;
 - Тэмцлийн ажилд хэрэглэгдэх техник тоног төхөөрөмжүүд дээр ажиллах улирлын болон түр ажилчдыг ажилчдыг дадлагажуулах;
- Тэмцлийн ажил явуулах бүс нутгийн ойн хөнөөлт шавж, өвчиний тархалтын тухай мэдээ, зураглалтай танилцах, тэмцлийн ажил явуулах газар нутгийг судлан холбогдох бэлтгэлийг хангах;
- Гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох

- Earthranger аппликашны эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээсэн байх;
- Гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлын байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршуутын мэдээг хуулж авч хадгалах;

ГЭРЛЭН УРХИ ТАВИХ АРГААР ТЭМЦЭХ

Доор дурдсан аймгуудын ойн сан бүхий сумдад тэмцэх ажлыг зохион байгуулна. Үүнд:

д/д	Тэмцлийн ажил явуулах сумын нэр	Тэмцэл явуулах талбай, га
1	Хэнтий аймгийн Баян-Адрага, Дадал сумын ойн санд	3000
	НИЙТ ДҮН	3000

д/д	Техникийн шаардлага	Нийлүүлэгчийн санал
1.	Өрөөсгөл хүр эрвээхэй мэдрэн татагдан ирэх зориулалт бүхий гэрлэн урхитай байх	
2.	50 ширхэг гэрлэн урхи, 10 ширхэг дэлгэц байрлуулах	
3.	Тэмцлийн ажил явуулах нийт талбайд 4-5 удаа зөөн байрлуулах боломжтой тооны гэрлэн урхи ажилд гарахад бэлэн байлгах	
4.	Ажил гүйцэтгэх хугацаанд ажлын онцлогоос хамааран 30 хоногийн хугацаанд багтаан тэмцлийн ажил явуулах боломжтой хэмжээний ажиллах хүчинтэй байх	
5.	Ажил гүйцэтгэх хугацаа: 2024.07.20 – 2024.08.20	

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажил явуулахаас өмнө тархалт голомтыг тогтоох судалгаа хийн дээж талбайн тооллогын хүснэгтийн дагуу тэмдэглэл үйлдсэн байна.

Багц тус бүрд гэрлийн долгион мэдэрч эрвээхэй татагдан ирэх тусгай зориулалт бүхий 50 ширхэг гэрлэн урхи, 10 ширхэг дэлгэц, 10 ширхэг цахилгаан мотор байхаар тооцож Өрөөсгөл хүр эрвээхэйн голомт бүхий талбайд байрлуулна. Гэрлэн урхи, дэлгэцийг 4-5 удаа зөөж байрлуулна.

Гэрлэн урхид орсон эрвээхэйг цуглувуулж тооллого хийн тооллогын хүснэгтэд тэмдэглэнэ.

Гэрлэн урхи болон дэлгэцэд орсон эрвээхэйг цуглувуулж төв суурин газарт ойр тохиолдолд төвлөрсөн хогийн цэг, болон

суурин газрын уурын зууханд орон нутгийн төлөөллийг оролцуулж акт үйлдэн галын аюулгүй байдлыг хангаж шатааж устгана.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх бүс нутагт хяналтын талбай байгуулан тэмцлийн өмнөх болон дараа харьцуулсан үр дүнг гаргасан байна.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил гүйцэтгэсэн хойш “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартын дагуу дээж талбайн тооллогын хүснэгтийн дагуу тэмдэглэл үйлдсэн байна.

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авахдаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-аас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явуулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцсон байна.

Тэмцлийн ажлын өмнөх судалгаа болон тэмцлийн ажлын үр дүн тооцох хүснэгтийг зааврын дагуу газар дээр нь бөглөсөн байх;

Тэмцлийн ажлын өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, газрын нэрээр гаргах, өдөр бүрийн гэрлэн урхи, дэлгэцэд орсон эр, эм эрвээхэйн тоог гаргаж, тэмцлийн ажлын маршут, хөдөлгөөнийг байршил тодорхойлогч багажаар бүртгэн явсан замыг ship өргөтгөлтэй файлаар хадгалах, ойн тархалтын зураг дээр тэмдэглэн танилцуулах зураг бэлтгэн товч тайлан гарган ажиллана.

Уг гүйцэтгэлийн өдөр тутмын товч тайлан мэдээг ажлын гүйцэтгэлд хяналт тавьж буй төслийн менежерийн анхны шаардлагаар саадгүй хувилан өгөх үүрэгтэй.

Гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлын хөдөлгөөнийг бүртгэх байршил тодорхойлох Earthranger аппликеийшнг гар утсанд суулган аж ахуйн нэгжийн нэр дээрх админ эрхээр замын зураглал бичих хэсгийг идэвхжүүлэн өдөр бүрийн нислэгийг замын зураглалыг Earthranger аппликеийшнд илгээсэн байна; /Админ эрхийг Ойн газраас нээлгэж авна/

Earthranger аппликеийшны эрхээр ойн хөнөөлт шавжийн судалгаа, тэмцлийн ажил, тэмцлийн ажил, тэмцлийн ажлын үр дүнг өдөр бүр зааврын дагуу илгээнэ.

Гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлын байршил тодорхойлох багаж /GPS/-аас өдөр бүрийн явсан маршутын мэдээг хуулж авч хадгална:

Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи, дэлгэц ашиглан тэмцэх ажлыг гүйцэтгэхдээ “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6532:2015”, стандартыг мөрдөж ажиллана.

Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлын хүрээнд “Ойн хөнөөлт шавжтай механик аргаар тэмцэх ажилд тавих ерөнхий шаардлага” MNS6537:2015, “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавих ерөнхий шаардлага” MNS 6534:2015 стандартуудын дагуу гэрлэн урхи,

дэлгэц байрлуулсан өдөр тутмын гүйцэтгэлийг хэсэглэл, ялгарал, газрын нэрээр гаргах, нэг гэрлэн урхи, дэлгэцэд хэчинээн тооны эрвээхэй орсныг хүйсээр ялан тэмдэглэх, гэрлэн урхи, дэлгэц тавьсан байршлыг харуулан аймаг, сум, баг, газрын нэр, хэсэглэл, ялгарлын дугаар бүхий ойн тархалтын зургийн хамт явцын болон эцсийн тайланда тусган явцын тайланг Ойн газарт ирүүлнэ.

Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх

Тэмцлийн ажил явуулсан талбайг орон нутгийн эрх бүхий албан тушаалтнаар батлуулан, захиалагчаас томилогдсон төслийн менежер, орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт актаар хүлээлгэн өгөх, актын эх хувийг тайланда хавсарган ирүүлнэ.

Тэмцлийн ажлын үр дүнг тооцоходоо “Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын үр дүнг тооцох ажилд тавигдах ерөнхий шаардлага MNS 6534:2015” стандартыг мөрдөж ажиллана. Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн аваадаа 1000 га хүртэлх талбайд 100 га тутамд нэг хяналтын дээж талбай, 1000 га-гаас дээш талбайд 500 га тутамд нэг хяналтын дээж талбай байгуулан тэмцлийн ажил явулахаас өмнө болон дараа нь тооллого хийн үр дүнг тооцон хүлээн авна.

Тэмцлийн ажлын техникийн үр дүн 90%-аас багагүй байхад тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн авна.

Зөрчил, гологдол арилгах

Тэмцлийн ажил явуулсан талбайг хүлээн аваад гарсан зөрчил дутагдлыг гүйцэтгэгч залруулах үүрэгтэй.

Тэмцлийн ажлын үр дүн заасан хувь хэмжээнд хүрээгүй тохиолдолд гүйцэтгэгч тэмцлийн ажлыг өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэж дахин комисст хүлээлгэн өгнө.

Энэхүү шаардлагыг биелүүлж ажиллахаа тендерт оролцогч захиалагчид албан бичгээр тодорхойлолт гаргаж өгөх үүрэгтэй.

Тайлан боловсруулах

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайланг аймаг тус бүрээр хийж захиалагчид 2 хувь ирүүлнэ. Тайлан доор дурдсан бүрдэл хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- a/ “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”;
- б/ 1:50000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцлийн ажил явуулсан талбайн зураг;
- в/ 1:100000-ны масштабтай ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг.

а. “Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан”-д: Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын судалгаа явуулан хөнөөлт шавжийн тархалт, голомт, хөнөөлийн голомт, дахин сэргэн ургах чадвараа алдсан талбайг ой зохион байгуулалтын материалын хэсэглэл ялгарлын талбай бүрээр гарган хүснэгтээр оруулна.

Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлыг гүйцэтгэсэн орон нутаг болон ЦУОШГ-аас тухайн бүс нутгийн сарын 10 хоногоор цаг уурын мэдээг тайланда хавсарган ирүүлнэ.

Түүнчлэн зонхилон хөнөөл учруулж буй шавжийн зүйлийн бүрэлдэхүүн, тэдгээрийн биологи, экологийн зарим онцлог шинжүүд, хөгжлийн үе шатуудын талаарх мэдээлэл, тоо толгойн

нягтшил, хэт олшролын өнөөгийн байдал, өсөлтийн динамик, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээллийг багтаана.

Дээж талбайн тооллого болон бусад судалгааны ажлын үед авсан гэрэл зураг, ойн төлөв байдлын зураг, хөнөөлт шавжид нэрвэгдсэн ойн ерөнхий байдлын зураг, тэмцлийн ажлын үр дүнд ой сэргэн ургасан байдлыг харьцуулсан зургийг тайланд хавсаргана.

Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлын бэлтгэл, зохион байгуулалт, гүйцэтгэсэн хугацаа, бүрэлдэхүүн, ажил гүйцэтгэсэн технологийн мэдээлэл, тэмцлийн ажил явуулсан талбайн мэдээллийг тайланд багтаах ба тэмцлийн ажил явуулсан талбайн зураг, орон нутагт хүлээлгэн өгсөн актыг эх хувиар хавсарган ирүүлнэ.

Түүнчлэн тэмцлийн ажил эхлэхийн өмнө дээж талбай байгуулан хөнөөлт шавжийн нягтшилыг тодорхойлсон мэдээллийг дээж талбай тус бүрээр, үр дүнг тооцохоор байгуулсан дээж талбай дээрх тооллогын мэдээллийг тооллого хийсэн өдөр тус бүрээр гарган тайланд оруулна.

б. “Ойн хөнөөлт шавжтай тэмцсэн ажил явуулсан талбайн зураг”-т: Хэсэглэл, ялгарлын хил, дугаар, талбай, газрын төрлийн ангилал тэмдэглэгээ, модны төрөл, насны бүлэг, газар ус, уул, өндөрлөг тоотын нэр, газар зүйн байрлалын солбицлын торлолд, зургийн масштаб, проекц, таних тэмдэг эдгээрийг ой зохион байгуулалтын технологийн зааварт заасан стандартын дагуу гүйцэтгэж оруулна.

Тэмцлийн ажил явуулсан талбайг арга тус бүрээр ялган харуулах ба талбайн хэмжээг тусад нь хүснэгтэд хийн зурагт хавсарган ирүүлнэ.

Ойн хөнөөлт шавжтай тэмцлийн ажил явуулсан талбайн зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

в. “Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зураг”-т ойн хөнөөлт шавж, өвчний тархалтыг зүйлийн бүрэлдэхүүн тус бүрээр гарган харуулна. Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын тойм зургийг сум тус бүрээр гарган тайланд хавсаргана.

Тайланг захиалагчийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээлгэн өгнө. Хэрэв тайланд зөрчил гологдол илэрсэн бол түүнийг арилгах үүргийг гүйцэтгэгч хүлээнэ.

Зөрчил гологдлыг арилгасан тухай төслийн менежер мэдэгдэл гарган дахин даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсны дараа эцсийн шатны санхүүжилтийг олгоно.

Зураг боловсруулалтын ажлыг Засгийн газрын 2009 оны 1-р сарын 28-ны өдрийн 25-р тогтоолын дагуу олон улсын WGS-84 солбицлын систем, өндрийн сүлжээний Балтийн тэнгисийн тогтолцоог, том дунд масштабын байр зүйн зураглалд дэлхийн хөндлөн меркаторын UTM (UNIVERSAL TRANSVERS MERCATOR) тусгагийг хэрэглэнэ.

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцсэн ажлын тайлан болон зургийн shp.файлуудыг цахим хэлбэрээр /CD, DVD/ 1 хувь ирүүлнэ.

Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх

МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫН ХАНГАМЖИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажлын тайлан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, Захиргаа, удирдлагын хэлтэс, Ойн нөөцийн хэлтэст тус тус нэг хувийг хүргүүлнэ. Тайланг зөвшөөрөх хугацааг ажлын үе шатны хуваарыт тусгасан болно. Тайланг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газарт нээлттэйгээр хэлэлцүүлнэ.

Тэмцлийн ажлыг зохион байгуулахад мэргэшсэн инженер техникийн болон улирлын ажилтнууд нь доорх шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

Ерөнхий инженер нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 5 жилийн туршлагатай байх, түүн дотроо гэрээг бие даан хариуцаж ажилласан 3 жилийн туршлагатай байх

Инженер техникийн ажилтан нь ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажил буюу гэрээгээр заасан ажилтай төрөл, үнийн дүнгээрээ ижил ажил гүйцэтгэсэн 3 жилийн туршлагатай байх 5.0 мян/га талбай тутамд ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд 5-аас дээш жил ажилласан мэргэшсэн инженер 2-ээс доошгүй, 5.0 мян/га талбай тутамд улирлын болон түр ажилтан 10-аас доошгүй байна.

Тэмцлийн ажлыг зохион байгуулахад бусад шаардлагатай ажилчидтай /тогооч, жолооч гэх мэт/ байх.

Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи тавих аргаар
тэмцэх талбайн байришил харуулсан зураг
Зураг төслийн жагсаалт /тендерт оролцогч ирүүлэх/

Д/Д	Зураг төслийн нэр	Агуулга
1.	Тэмцлийн ажил явуулах талбайн зураг	Тэмцлийн ажил явуулахаар төлөвлөж буй аймаг, сум тус бүрээр гаргах ба зурагт ойн хөнөөлт шавж, өвчний төрөл зүйл, ажил гүйцэтгэх арга технологи тус бүрээр газар нутгийн тэмдэглэх, ажил гүйцэтгэх хугацааг харуулсан байх
2.	Тэмцлийн ажилд ашиглах багажийн гэрэл зураг	Багаж, хэрэгсэлийн маркыг бүрэн гүйцэд харуулсан байх
3.	Тэмцлийн ажилд ашиглах автомашинуудын гэрэл зураг	Ажилд ашиглах машинуудын зургийг тус бүрд нь харуулах

ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

Д/Д	Ажлын нэр, тодорхойлолт	Тоо, хэмжээ	Нийлүүлэх хуваарь
1	Бэлтгэл ажил	-	2024-07-15-ны дотор
2	Гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажил	3000 га	2024-08-10-ны дотор
3	Тэмцсэн талбайг хүлээлгэн өгөх	3000 га	2024-08-20-ны дотор
4	Зөрчил, гологдол арилгах	3000 га	2024-08-25-ны дотор
5	Тайлан боловсруулалтын ажил	-	2024-10-01-ний дотор
6	Тайланг хэлэлцүүлэн хүлээлгэн өгөх	-	2024-11-10-ны дотор

ХАВСРАЛТ 2

**ОЙН ХӨНӨӨЛТ ШАВЖТАЙ ГЭРЛЭН УРХИ, ДЭЛГЭЦ ТАВИХ АРГААР
ТЭМЦЭХ АЖИЛ ЯВУУЛАХ ГАЗАР НУТАГ**

д/д	Сумын нэр	Тэмцлийн ажил явуулах		Ой зохион байгуулалт хийсэн он	Зүйлийн нэр
		Талбай (га)	Хэсэглэлийн дугаар		
Хэнтий аймаг					
1	Баян-Адрага, сумын ойн санд	3000	10, 11, 15, 16, 23, 31, 35, 40, 47, 50	2013	Өрөөсгөл хүр эрвээхэй
	Дадал сумын ойн санд		45, 67, 72, 113, 136, 140, 202, 294, 300		
ДҮН		3000	-	-	-

IV БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн санаалаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Ажил дуусгах хугацаа: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих*]

Хэрэв “ashiagh” бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарыт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарыт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд [хувь бичих]-аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.

Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарыт зааснаас [*тоо бичих*]-аас илүү [*“car”, “өдөр” гэдэг үгнээс сонгож бичих*] хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин Өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж узнэ.

1. Бараа, ажил, үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих*.]

Хэрэв “ashiagh” бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

2. Байгаль орчинд нөлөөлөх байдал: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих*.]

Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

3. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: [*“Ашиглана” эсхүл “Ашиглахгүй” гэж бичих*.]

Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. [Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]

4. Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөхцлийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, хулэмжийн хийн ялгарал

болов хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн бараа нийлүүлэх тендерийн харьцуулах унийг дараах байдлаар тодорхойлж болно.

V БҮЛЭГ. ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ

Маягт 1. Тендер илгээх

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

Маягт 1. Тендер илгээх

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендер шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендер шалгаруулалтын баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих]. [Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих].
5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [ажлын 30 ба түүнээс дээши өдрийн тоо] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Хуулийн 7.1, 22.2, 56.5-д заасныг зөрчсөн болон тендер шалгаруулалтад үнэн зөв, зөрүүгүй орчуулга ирүүлэх үүргээ зөрчсөн тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэх үндэслэл болохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон ажил болон тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотой бараа, үйлчилгээ нь оюуны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.
8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

*[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:*

Хаяг:

Маягт 2. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 3. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	/“Өөрийн эзэмшил” эсхүл “турээс” аль нэгийг бичих/

Маягт 4. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 5. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 6. Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Тендерт оролцгчийн нэр: [түншилэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 7. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

	Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Нууцалсан хууль зүйн үндэслэл
1.		
2.		
3.		

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж ажил гүйцэтгүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
7. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Ажил” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын талбай” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх

нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

Тайлбар

- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
 - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
 - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- | | | |
|------------------------|---------|---|
| Захиалагчийн
үүрэг | нийтлэг | 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө.
2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө.
2.3. Захиалагч нь ажил гүйцэтгүүлэхтэй холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна.
2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно.
2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Захиалагчийн төлөөлөгч | нэвтрэх | 2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно.
2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна. |
| Талбайд
зөвшөөрөл | | |

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | | |
|------------------------|---------|---|
| Гүйцэтгэгчийн
үүрэг | нийтлэг | 3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.
3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.
3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.
3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусдад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.
3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.
3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй. |
|------------------------|---------|---|

- | | |
|--|--|
| <p>Гүйцэтгэгчийн төлөөлөгч</p> <p>Техникийн болон ажлын талбайн өгөгдөл</p> <p>Ажлын талбайн харуул хамгаалалт</p> <p>Хог, хаягдал ба нөхөн сэргээлт</p> <p>Археологийн болон бусад олдвор</p> | <p>3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.</p> <p>3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.</p> <p>3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> <p>3.11. Захиалагч нь ажлын талбайн байр зүйн, геологийн, гидрогеологийн, цаг уурын болон байгаль орчны нөхцөлийн талаарх, өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.</p> <p>3.12. Гүйцэтгэгч нь зөвшөөрөлгүй этгээдийг ажлын талбайд оруулахгүй байхаар зохион байгуулна.</p> <p>3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбайг хамгаалах, талбайд ажиллагсад болон зорчигчийн аюулгүй байдал, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах зорилгоор шаардлагатай газруудад гэрэлтүүлэг тавих, хашаа барих, харуул хамгаалалттай холбогдон гарах зардлыг хариуцна.</p> <p>3.14. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх явцад ажлын талбайд саад болох хог хаягдал болон цаашид ашиглагдахгүй болсон бараа материал, эд зүйл, тоног төхөөрөмж, машин механизмыг өөр газарт шилжүүлэх зэрэг арга хэмжээ авч ажлын талбайг цэвэр байлгана.</p> <p>3.15. Гүйцэтгэгч нь ажлын талбайд авчирсан аюултай материалуудыг зохих ёсоор хадгалж, устгана.</p> <p>3.16. ГЕН-ийн 3.14-3.15-д заасан үүргээ биелүүлэгчий тохиолдолд түүнтэй холбоотой аливаа үр дагаврыг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.17. Ажлын талбай дээрээс олдсон археологийн болон бусад олдвор (бүх чулуужсан амьтан, ургамлын үлдэгдэл, зоос, үнэт зүйлс, бусад эртний олдвор, геологийн болон археологийн ач холбогдол бүхий зүйлс гэх мэт бусад) олдсон тохиолдолд захиалагчид мэдэгдэн, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүлээлгэн өгнө.</p> <p>3.18. Гүйцэтгэгч олдворыг гэмтэхээс сэргийлж зохих арга хэмжээ авна.</p> |
|--|--|

Аюулгүй байдал

- 3.19. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.
- 3.20. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.
- 3.21. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.
- 3.22. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.23. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.24. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.25. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

- 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
 - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
 - 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
 - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ

- биелүүлээгүй;
- 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.
- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- Ажлын явцын тайлан**
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайландаа үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.
- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсралт, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- Гэрээний үнэ**
- 5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
- 5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- Урьдчилгаа төлбөр**
- 5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
- 5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.
- Төлбөрийн нөхцөл**
- 5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
- 5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн

- тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
 - 5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
 - 5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
 - 5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | | |
|------------------------|-----------------------|--|
| Урьдчилгаа
баталгаа | төлбөрийн
баталгаа | 6.1. ГЕН-ийн 5.4-т заасны дагуу урьдчилгаа төлбөр олгооор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| | | 6.2. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | | 6.3. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна: <ol style="list-style-type: none"> 6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй; 6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй; 6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | | 6.4. Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | | 6.5. ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| | | 6.6. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар |

- Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө.
- | | |
|-------------------|--|
| Чанарын баталгаа | <p>6.7. Ажлын чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана.</p> <p>6.8. Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно.</p> <p>6.9. ГЕН-ийн 6.7-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.</p> <p>6.10. Баталгаат хугацаанд ажилд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.</p> <p>6.11. ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно.</p> <p>6.12. ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.</p> <p>6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.</p> <p>6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.</p> |
| Баталгаат хугацаа | |

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- | | |
|--------------------------------------|--|
| Бусдад учруулсан
хохирлыг арилгах | <p>7.1. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p> |
| Захиалагчийн
эрсдэл | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. ажлын үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн ажлыг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p> <p>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас ажил, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;</p> |

- 7.3.4. Захиалагчийн зураг төслийн алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.
- 7.4. Ажлын доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.
- Даатгал**
- 7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.
- 7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.
- 7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.
- 7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- Доголдлыг арилгах илрүүлэх,
- 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн ажил, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна.
- 8.2. Захиалагчийн төлөөлөгч ажлын явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө.
- 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ.
- 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ.
- 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
- 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно.
- 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө.

- Далд доголдол
- Зураг төслийн доголдол
- Захиалагч гэрээг цуцлах
- 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана.
- 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна.
- 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна.
- ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ**
- 9.1. Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
- 9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлын 5 хоног ажлын талбайг орхисон;
- 9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гаралаагүй;
- 9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн;
- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.

- | | | |
|---|---|---|
| <p>Гүйцэтгэгч гэрээг цуцлах</p> <p>Гэрээг цуцлах журам</p> <p>Гэрээг цуцалсны дараах төлбөр</p> | <p>9.3.</p> <p>9.4.</p> <p>9.5.</p> <p>9.6.</p> <p>9.7.</p> <p>9.8.</p> <p>9.9.</p> | <p>Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:</p> <p>9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;</p> <p>9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;</p> <p>9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.</p> <p>Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.</p> <p>Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.</p> <p>Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.</p> <p>Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.</p> <p>ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.</p> <p>ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:</p> <p>9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;</p> <p>9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;</p> <p>9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх</p> |
|---|---|---|

шаардлагатай болсон аливаа төлбөр;

9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;

9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

Мэдэгдэл

10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.

10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.

10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.

10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:

10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;

10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.

10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.

10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.

10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.

10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.

10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд

Төлөөлөгч өөрчлөгдөх

			хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
Ажилд залруулга хийх нөхцөл	өөрчлөлт,	10.12.	Талууд ажлын чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын өрөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
		10.13.	Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
		10.14.	Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
		10.15.	Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
Гэнэтийн давагдашгүй шинжтэй онцгой байдал	буюу хүчний нөхцөл	10.16.	Ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
		10.17.	Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
		10.18.	Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.
		10.19.	Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дунд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
Оюуны зөрчих	өмчийн эрх	10.20.	Ажлыг гүйцэтгэх явцад болон ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
Алданги		10.21.	Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
		10.22.	Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд

гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.

- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Маргаан шийдвэрлэх

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 4.1. Ажил эхлэх хугацаа: **2024.07.20**
- ГЕН 4.2. Ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлэх хугацаа: **2024.07.20**
Шаардлагатай мэдээллийг урьдчилан авна.
- ГЕН 4.9. Ажлын явцын тайлан гаргах хуваарь болон ирүүлэх хугацаа: **2024.08.01**
- ГЕН 5.2. Үнийн тохируулга: **ХИЙХГҮЙ**
- ГЕН 5.4. Урьдчилгаа төлбөр олгох эсэх: **ҮГҮЙ**
- ГЕН 5.5. Урьдчилгаа төлбөр олгох хугацаа: **ҮГҮЙ**
- ГЕН 5.6. Төлбөр төлөх хугацаа: **АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛЭЭР ТООЦНО.**
- ГЕН 6.1. Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: **ҮГҮЙ**
Урьдчилгаа төлбөрийн баталгаа ирүүлэх хугацаа: /ШААРДАХГҮЙ/
- ГЕН 6.7. Чанарын баталгаа: “ШААРДАНА”
Чанарын баталгааны хэмжээ: **ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 5 ХУВЬ**
- ГЕН 6.13. Баталгаат хугацаа: **365 ХОНОГ**
- ГЕН 7.5. Даатгал: **ГҮЙЦЭТГЭГЧ ХАРИУЦНА.**
- ГЕН 10.21. Захиалагчийн төлөх алдангийн хувь:
Алдангийн хувь: **0.5 хувь**
- ГЕН 10.22. Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:
Алдангийн хувь: **ХОНОГ ТУТАМД ГЭРЭЭНИЙ ҮНИЙН ДҮНГИЙН 0.5 ХУВЬ**

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн нэрийг бичих] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Ажил” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Ажлын үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч [Гүйцэтгэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - 3.7. Техникийн тодорхойлолт;
 - 3.8. Ажил гүйцэтгэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:

Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

- 4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл
Эцэг/эх-ийн нэр:
Нэр:
Албан тушаал:
Ажлын утас:
Гар утас:
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____
ТАМГА